МОНГОЛ УЛСЫН
ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ ЯАМ

Сүхбаатарын талбай 1, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160
Утас: 33 07 81, Факс: (976-11) 33 07 80,
Цахим шуудан: info@mddc.gov.mn
Цахим хуудас: www.mddc.gov.mn

2024.02.09 № 03/259.

танай ____________ -ны № ____________ -т

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАРТ

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны “Ил тод байдлын шалгуур үзүүлэлт”-ийн 2023 оны жилийн эцсийн биелэлтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн үүгээр хүргүүлж байна.

Хавсралт 13 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Б.БАТЦЭЦЭГ

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны
Төрийн нарийн бичгийн даргын 2024.
оны 02 дугээр сарын 09.-ны өдрийн
03/259 дугаар албан бичгийн хавсралт

# ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ "ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ"-ИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

2024 оны 02 дугаар сарын 06 | № | Улаанбаатар хот

## Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Байгууллагын 2023 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, гүйцэтгэлийг нь тогтоон үр дүнг үнэлэн, зөвлөмж, дүгнэлт гаргаж, удирдлагыг үнэн зөв бодит мэдээллээр ханган, ил тод байдлын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд оршино.

## Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Хяналтад авсан хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.7-д заасны дагуу Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийн үнэлгээ хийх аргачлалыг удирдлага болгон үнэлсэн болно.

## Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний хамрах хүрээ

Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан /new.unelgee.gov.mn/-д Цахим хөгжил, харилцаа холбооны яамны чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдалд хамаарах 10, хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдалд хамаарах 6, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдалд хамаарах 15, үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдалд хамаарах 2, бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдалд хамаарах 13 буюу нийт 46 үзүүлэлтийн хүрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

## Дөрөв. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт

Нийт 46 шалгуур үзүүлэлтийн дагуу гаргасан тайлангаар 96.11% хувь буюу 2023 онд багтааж ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан 34, хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй 10 үзүүлэлт байна.

Хэрэгжилтийн хугацаа тооцох болоогүй 2 шалгуур үзүүлэлтийг дурдвал:

1.“2.4.Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам”-ыг ил тод байршуулах шалгуур үзүүлэлтийн хувьд 2024 оны 1 дүгээр улиралд багтаан баталж байршуулах нь зүйтэй байна;

2.“3.3.Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт”-ийг ил тод байршуулах шалгуур үзүүлэлтийн хувьд “Мэдээлэх хугацаа болоогүй” гэж тайлагнасан бөгөөд дээрх ил тод байршуулах шалгуур үзүүлэлтийн тухайд хуулийн хугацаандаа буюу 2024 оны 1 дүгээр улиралд багтаан мэдээлэл байрших бүрэн боломжтой байна.

Мөн цаг үеийн шинжтэй буюу одоогоор тухайн төрлийн мэдээлэл байхгүй ч ирээдүйд бий болсон тохиолдолд тайлагнах боломжтой ил тод байршуулах шалгуур үзүүлэлтийг дор дурдвал:

1.“5.2.Эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт”-ыг ил тод байршуулах шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн хувьд “Тус яаманд хамаарах оюуны өмч байхгүй болно” гэж;

2.“5.4. Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл”-ийг ил тод байршуулах шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн хувьд “Тус яамны эзэмшилд газар байхгүй тул мэдээлэл оруулах боломжгүй байна” гэж;

3.“5.12.Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт”-ийг ил тод байршуулах хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтийн хувьд “Цахим хөгжил, харилцаа холбооны яамны зардлаар суралцаж байгаа суралцагч байхгүй байна” гэж тус тус тайлагнажээ.

Бусад шалгуур үзүүлэлтийн хувьд тус яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахгүй буюу цаашид ил тод тайлагнах боломжгүй байх тул хасуулах шаардлагатай байна. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хувьд цөөн мэдээллүүдийг хугацаа хоцроосон төлөвтэй боловч ил тодоор байршуулсан тул хэрэгжилт хангалттай гэж үзсэн болно.

Мөн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг даган гарсан Монгол Улсын Засгийн газрын 2022 оны "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам батлах тухай" 352 дугаар тогтоолоор тус яам өөрт хамаарах 68 төрлийн мэдээллийг ил тод байршуулсан. Үүний зэрэгцээ Монгол Улсын Засгийн газар 2023 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарлаж, авлигатай тэмцэх таван Ш буюу Шүгэл, Шүүр, Шувуу, Шилжүүлэн авах болон Шил ажиллагааг хэрэгжүүлсэн. Иргэдийн мэдээлэл хайх, мэдээлэл хүлээн авах эрхийг хангах, “Шил ажиллагаа”-ны хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны яам тэргүүлэн ажилласан.

Ингэснээр төрийн байгууллагуудын мэдээллээ нээх үйл явц эрчимжиж, Shilen.gov.mn сайтад нийтэлж эхэлсэн. Шил ажиллагааны гол зорилго бол төрд хэн, хаана, хэзээ, юу хийж байгааг иргэд нь шууд харж хянаж, хулгайг хийх боломжийг технологийн шийдлээр хааж хумих юм. shilen.gov.mn платформыг 2023 оны гуравдугаар сарын 27-ны өдөр “Шилэн” ажиллагааны хүрээнд нээсэн бөгөөд “Таны төр-Та хяна” уриалгийг олон нийтэд дэвшүүлсэн. Уг платформ мэдээлэл хариуцагчдаас ирүүлсэн, хуулиар ил болгох ёстой мэдээллүүдийг нэгтгэн иргэд, олон нийт, хэвлэл мэдээллийнхэнд нэг цонхоор мэдээлэлд хяналт тавих боломжийг олгож буй. Шил ажиллагааны “shilen.gov.mn” системд нийт 39 төрлийн 970,355 нэгж

мэдээллийг 2008 оноос хойших байдлаар түүхчлэн байршуулж, нийт 8,889,892 удаагийн хандалтыг аваад байна. Үүнд:

1.Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутагт эрх бүхий албан байгууллагаас 4,568 га газрыг 2,079 хүн, хуулийн этгээдэд олгосон талаарх мэдээлэл;

2.Хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээний явцад хийгдсэн байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийн нийт 15,508 мэдээлэл;

3.Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын 8,437 дүгнэлт, комисст ажилласан 135,102 албан хаагчийн мэдээлэл;

4.Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой төлөөлөн удирдах зөвлөл бүхий 238 хуулийн этгээдийн 1,634 төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн нэрс, цалингийн мэдээлэл;

5.Төрийн өмчийн 310 объектыг түрээсэлж буй 1,572 түрээслэгчийн 2944 түрээсийн мэдээлэл;

6.Монгол Улсын Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар нийт 24 тусгай сан үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэл, санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг байршуулсан. Эдгээр тусгай сангаас эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг, зээл, туслалцаа өгдөг 7 тусгай сан байдаг ба мэдээллийг нээлттэй ил тод байршуулснаар 23.5 тэрбум төгрөг, 1,012,220 ам.долларын эргэн төлөлт хийгдсэн үр дүн гарсан. Үүнд:

- Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн 2009-2022 оны хооронд нийт 1,099 хүн, хуулийн этгээдэд олгосон 1 их наяд төгрөгийн зээлийн мэдээллийг жагсаалтын хамт;

- Хөдөө аж ахуйг дэмжих сангаас 1994–2022 оны хооронд нийт 9,387 хүн, хуулийн этгээдэд олгосон 183.8 тэрбум төгрөгийн зээлийн мэдээлэл болон 147.9 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдлийн талаарх мэдээллийг жагсаалтын хамт;

- Улсын авто замын сангийн 2008–2023 оны хооронд нийт 107 хуулийн этгээдэд олгосон 540 төсөл, хөтөлбөрийн 220 тэрбум төгрөгийн зарцуулалтын талаарх мэдээллийг жагсаалтын хамт;

-Соёл, урлагийг дэмжих сангийн 2020–2022 оны хооронд нийт 219 хүн, хуулийн этгээдэд олгосон 6,5 тэрбум төгрөгийн зарцуулалтын талаарх мэдээллийг жагсаалтын хамт;

- Кино урлагийг дэмжих сангийн 2023 онд 11 хүн, хуулийн этгээдтэй байгуулсан 1 тэрбум төгрөгийн санхүүжилт, одоо хэрэгжиж байгаа гэрээний мэдээллийг жагсаалтын хамт;

- Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн 2012–2023 оны хооронд гэмт хэргийн хохирогч болсон 468 иргэнд олгосон 2,6 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр, 1,6 тэрбум төгрөгийн авлагын талаарх мэдээллийг жагсаалтын хамт;

- Боловсролын зээлийн сангийн 2007-2023 оны хооронд нийт 1,497 суралцагчид гадаадын зээл, тэтгэлгийн чиглэлээр олгосон 324 тэрбум төгрөгийн санхүүжилт, түүнээс 316 тэрбум төгрөгийн зээлийн мэдээллийг жагсаалтын хамт;

- Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2017-2023 оны хооронд давхардсан тоогоор 666 байгууллага, 18,477 суралцагчид олгосон 72.2 тэрбум төгрөгийн зарцуулалтын мэдээллийг жагсаалтын хамт;

- Шинжлэх ухаан, технологийн сангийн 2007–2022 оны хооронд нийт 381 хүн, хуулийн этгээдэд олгосон 2,780 төсөл, хөтөлбөрийн 151.9 тэрбум төгрөгийн зарцуулалтын талаарх мэдээллийг жагсаалтын хамт;

- Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2013-2022 оны хооронд 724 хүн, хуулийн этгээдэд олгосон 1,095 төсөл, хөтөлбөрийн 17.7 тэрбум төгрөгийн зарцуулалтын талаарх мэдээллийг жагсаалтын хамт;

- Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангаас 2009-2023 оны хооронд 2,000 гаруй иргэнд 3.1 тэрбум төгрөгийн тусламж олгосон талаарх мэдээллийг жагсаалтын хамт;

- Нийгмийн халамжийн сангийн 2008-2022 оны хооронд орлого, зарлагын мэдээллийг, 2016-2022 оны хооронд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт, ахмад настанд үзүүлсэн тусламж хөнгөлөлт, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг үзүүлдэг 967 хуулийн этгээдэд олгосон санхүүжилтийн мэдээллийг жагсаалтын хамт;

- Нийгмийн даатгалын сангийн 2008-2022 оны хооронд орлого, зарлагын мэдээллийг, 2010-2020 оны банканд байршуулсан мөнгөн хөрөнгийн дүн, хүүгийн орлогын мэдээллийг жагсаалтын хамт;

- Хүүхдийн төлөө сангийн 2021-2023 оны хооронд нийт 11 тэрбум төгрөгийн хуримтлалыг үүсгэсэн ба үүнээс 106.7 сая төгрөгийг нийт 45 хүүхдэд 2 төрлөөр зарцуулсан талаарх мэдээлэл;

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2012-2022 оны хооронд давхардсан тоогоор 1.8 сая иргэнд 628.7 тэрбум төгрөгийн зарцуулалт хийсэн ба үүний 122.2 тэрбум төгрөг нь санхүүгийн дэмжлэг хэлбэрээр олгогдсон, нийт 58.2 тэрбум төгрөгийн авлагатай байгаа талаарх мэдээллийг жагсаалтын хамт;

- Ирээдүйн өв сангийн 2017-2022 оны орлого, зарлагын мэдээлэл;

- Төсвийн тогтворжуулалтын сангийн 2011-2022 оны орлого, зарлагын мэдээлэл;

- Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018-2022 оны хооронд орлого, зарлагын мэдээллийг жагсаалтын хамт;

- Эрүүл мэндийг дэмжих сангийн 2008-2023 оны хооронд нийт 3092 хуулийн этгээдэд 1.7 их наяд төгрөгийн санхүүжилт олгосон мэдээллийг жагсаалтын хамт;

- Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2009-2022 оны хооронд 484 хуулийн этгээдээс нийт 47,4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүлж, 155 төсөл, хөтөлбөрийн санхүүжүүлэлтэд 38.6 тэрбум төгрөг зарцуулсан талаарх мэдээллийг жагсаалтын хамт;

- Спортын дэмжих сангийн 2017–2019 оны хооронд нийт 57 хуулийн этгээдэд олгосон 66 төсөл, арга хэмжээний 4.9 тэрбум төгрөгийн зарцуулалтын талаарх мэдээлэл;

Төрийн байгууллагын нээлттэй, ил тод мэдээлэлд үнэлгээг 7 хоног бүр хийж, үндэсний хэмжээнд "Шилэн Индекс"-ийн үзүүлэлтийг зарласан. Үүнд:

1.Төрийн захиргааны төв байгууллагын хувьд дундаж үзүүлэлт 97%,

2.Төрийн захиргааны байгууллагуудын хувьд дундаж үзүүлэлт 81.53%,

3.Нутгийн захиргааны байгууллагуудын хувьд дундаж үзүүлэлт 90.65%,

4.Нийслэлийн дүүргийн хувьд дундаж үзүүлэлт 96.35%,

5.Төрийн өмчит үйлдвэрийн газар болон бусад төрийн байгууллагууд 40.99%-тай тус тус үнэлэгдсэн.

"Шилэн Индекс"-ийн үзүүлэлтийг анх үнэлэхэд нийт 135 байгууллагын хүрээнд 31%-тай байсан бол одоогийн байдлаар 81.3%-тай болж сайжирсан сайн үр дүн гарсан байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь 2023 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ яамны цахим хуудас /mddc.gov.mn/-ны мэдээлэл, мэдээллийн самбар, бусад мэдээллийн хэрэгсэл ашиглан нийтэлж байгаа эсэх, мэдээллийг ил тод үнэн зөвөөр мэдүүлсэн эсэхэд хяналт тавьж, хэрэгжилтийн тайланг жил бүрийн 3 дугаар сарын 1-ний өдөрт багтаан тайлагнаж байна.

Тус яам нь 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрөөс үйл ажиллагаа явуулж эхэлсэн ба шинэчлэн батлагдсан хууль тогтоомж, холбогдох журмын дагуу цахим хуудастаа ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг бүрэн дүүрэн шинэчлэн оруулсан эсэхийг нягтлан, дараах зүйлсийг харгалзан үзэж хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн болно. Үүнд:

1.Яамны цахим хуудас болоод мэдээллийн цахим самбарт шалгуур үзүүлэлтүүдийг тухай бүр ойлгомжтой байдлаар байршуулж, байгаа эсэх;

2.Хуулийн хугацаатай /шилэн данс г.м/ ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг өдөр тутамдаа хэрэгжүүлж байгаа эсэх.

## Тав. Зөвлөмж

Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг үнэлэхэд дараах зөвлөмжийг Төрийн захиргааны удирдлагын газарт өгч байна.

1.Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журмын хавсралтын дагуу жил бүрийн 02 дугаар сарын 20-ны өдөрт багтаан ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг хангасан хэрэгжилтийн тайланг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хамаарах баримтын хамт хүлээлгэн өгч хэвшсэн байх;

2.Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн мэдээллийг байгууллагын цахим хуудаст иргэдэд ойлгомжтой байдлаар бэлтгэн байршуулж байх/ Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам, Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт/;

3.Мэдээллийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу нотлох баримттайгаар тайлагнаж хэвших.

Нээлттэй мэдээллийг цахим хуудас, мэдээллийн самбар, бусад мэдээллийн хэрэгсэл ашиглан нийтэлсэн бол шалгуур үзүүлэлт тус бүрийг хангалттай оноогоор дүгнэх боломжтой гэдгийг онцлох нь зүйтэй байна.

-оОо-

## Ил тод байдлын шалгуур үзүүлэлт
## Цахим хөгжил, харилцаа холбооны яамны
## 2023 оны жилийн эцсийн тайлан

| Д/д | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|
| Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал | | | |
| 1 | 1.1. Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн; | Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт болон Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг “Алсын хараа – 2050”, Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт олон улсад өрсөлдөх чадвар бүхий үндэсний шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх замаар эдийн засгийн тэргүүлэх чиглэлийн нэг болгох зорилт тавьж, “Цахим Үндэстэн” болох уриалгыг дэвшүүлсэн. Энэхүү ажлын хүрээнд дижитал дэд бүтэц, цахим засаглал, мэдээллийн аюулгүй байдал, тоон бичиг үсгийн чадавх, инновац үйлдвэрлэл, үндэсний хөгжлийн хурдасгуур гэсэн стратегийн зургаан том төлөвлөгөөг баталсан бөгөөд яамны цахим хуудасны “яамны тухай” цэсийн “стратегийн зорилго” цэсэд https://mddc.gov.mn/mn/%d1%81%d1%82%d1%80%d0%b0%d1%82%d0%b5%d0%b3%d0%b8%d0%b9%d0%bd-%d0%b7%d0%be%d1%80%d0%b8%d0%bb%d0%b3%d0%be/ байршуулсан болно. | 100% |
| 2 | 1.2. Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг; | Цахим хөгжил, харилцаа холбооны яамны чиг үүрэг бүтэц зохион байгуулалт, хаяг байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаягийг ил тод бүрэн байршуулсан. Линк 1 чиг үүрэг: https://mddc.gov.mn/mn/%d1%81%d1%82%d1%80%d0%b0%d1%82%d0%b5%d0%b3%d0%b8%d0%b9%d0%bd-%d0%b7%d0%be%d1%80%d0%b8%d0%bb%d0%b3%d0%be/<br>Линк 2 бүтэц зохион байгуулалт: https://mddc.gov.mn/mn/%d0%b1%d2%af%d1%82%d1%8d%d1%86-%d0%b7%d0%be%d1%85%d0%b8%d0%be%d0%bd-%d0%b1%d0%b0%d0%b9%d0%b3%d1%83%d1%83%d0%bb%d0%b0%d0%bb%d1%82/<br>Линк 3 хаяг байршил харилцах утасны дугаар шуудангийн хаяг олон нийттэй харилцах мэдээлэл түгээх нийгмийн сүлжээний хаягийг байршуулсан:https://mddc.gov.mn/mn/<br>Линк4 албан хаагчдын мэдээлэл: https://mddc.gov.mn/mn/%d0%b0%d0%bb%d0%b1%d0%b0%d0%bd-%d1%85%d0%b0%d0%b0%d0%b3%d1%87%d0%b4%d1%8b%d0%bd-%d0%bc%d1%8d%d0%b4%d1%8d%d1%8d%d0%bb%d1%8d%d0%bb-2/ | 100% |
| 3 | 1.3. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, | Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт батлах тухай” 55 дугаар тогтоолд өөрчлөлт оруулсны дараагаар уг тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмжийг оруулахаар байна. Мөн мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, албан шаардлага, зөвлөмжийг “ил тод байдал” | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж; | цэсийн “үйл ажиллагааны ил тод байдал” дэд цэсийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан хэсэгт тус яаманд хамаарах тайлангуудыг байршуулсан. Линк1: https://mddc.gov.mn/mn/%d1%82%d0%b0%d0%b9%d0%bb%d0%b0%d0%bd/ | |
| 4 | 1.4. Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан; | Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан яамны цахим хуудасны “ил тод байдал” цэсийн “үйл ажиллагааны ил тод байдал” дэд цэсийн үйл ажиллагааны тайлан хэсэгт https://mddc.gov.mn/mn/%d1%82%d0%b0%d0%b9%d0%bb%d0%b0%d0%bd/ тухай бүр байршиж байна. | 100% |
| 5 | 1.5. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан; | Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайланг яамны цахим хуудасны “ил тод байдал” цэсийн “үйл ажиллагааны ил тод байдал” дэд цэсийн үйл ажиллагааны тайлан https://mddc.gov.mn/mn/%d1%82%d0%b0%d0%b9%d0%bb%d0%b0%d0%bd/ хэсэгт тухай бүр оруулж байна. | 100% |
| 6 | 1.6. Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт; | Цахим хуудасны яамны тухай цэсийн, Хууль эрх зүй дэд цэсэд байршуулсан “Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт” хэсэгт https://mddc.gov.mn/mn/%d1%85%d1%83%d1%83%d0%bb%d1%8c-%d1%8d%d1%80%d1%85-%d0%b7%d2%af%d0%b9/ байршсан. | 100% |
| 7 | 1.7. Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг; | Цахим хөгжил, харилцаа холбооны яамны цахим хаягт яамны тухай хэсэгт албан хаагчийн нэр, албан тушаал, харилцах утасны дугаар, цахим шуудангийн хаягийг байршуулсан. Линк https://mddc.gov.mn/mn/%d0%b0%d0%bb%d0%b1%d0%b0%d0%bd-%d1%85%d0%b0%d0%b0%d0%b3%d1%87%d0%b4%d1%8b%d0%bd-%d0%bc%d1%8d%d0%b4%d1%8d%d1%8d%d0%bb%d1%8d%d0%bb-2/ Мөн Албан тушаалын тодорхойлолтыг яамны цахим хуудасны ил тод байдал хэсгийн хүний нөөцийн ил тод байдал хэсэгт оруулсан болно. Линк:https://mddc.gov.mn/mn/%d0%b0%d0%bb%d0%b1%d0%b0%d0%bd-%d1%85%d0%b0%d0%b0%d0%b3%d1%87%d0%b4%d1%8b%d0%bd-%d0%bc%d1%8d%d0%b4%d1%8d%d1%8d%d0%bb%d1%8d%d0%bb-2/ | 100% |
| 8 | 1.8. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ; | Цахим хуудасны “Ил тод байдал” цэсийн “Үйл ажиллагааны ил тод байдал” цэсэд https://mddc.gov.mn/mn/%d3%a9%d1%80%d0%b3%d3%a9%d0%b4%d3%a9%d0%bb-%d0%b3%d0%be%d0%bc%d0%b4%d0%be%d0%bb-%d1%88%d0%b8%d0%b9%d0%b4%d0%b2%d1%8d%d1%80%d0%bb%d1%8d%d0%bb%d1%82/ “Өргөдөл гомдол шийдвэрлэлт” байршсан. | 100% |
| 9 | 1.9. Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл; | Цахим хуудасны “мэдээ” цэсийн “статистик” хэсэгт https://dashboard.mddc.gov.mn/ салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл байршсан. | 100% |
| 10 | 1.10. Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр; | Цахим хуудасны “мэдээ” цэсэд https://mddc.gov.mn/mn/%d1%85%d3%a9%d1%82%d3%a9%d0%bb%d0%b1%d3%a9%d1%80/ тухай бүр байршиж байна. | 100% |
| Хоёр. Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал | | | |
| 11 | 2.1. Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл; | Цахим хуудаст “Ил тод байдал” цэсийн “Хүний нөөцийн ил тод байдал” дэд цэсэд https://mddc.gov.mn/mn/%d1%81%d1%83%d0%bb-%d0%be%d1%80%d0%be%d0%bd- | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | %d1%82%d0%be%d0%be%d0%bd%d1%8b-%d0%b7%d0%b0%d1%80/ Төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалтын мэдээ материалыг тухай бүр оруулан ажиллаж байна. | |
| 12 | 2.2. Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам; | Цахим хуудаст “Ил тод байдал” цэсийн “Хүний нөөцийн ил тод байдал” дэд цэсэд https://mddc.gov.mn/mn/%d1%85%d2%af%d0%bd%d0%b8%d0%b9-%d0%bd%d3%a9%d3%a9%d1%86%d0%b8%d0%b9%d0%bd-%d1%83%d0%b4%d0%b8%d1%80%d0%b4%d0%bb%d0%b0%d0%b3%d0%b0/ Төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулах журам байршсан. | 100% |
| 13 | 2.3. Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм; | Цахим хуудасны ил тод байдал цэсний Хүний нөөцийн ил тод байдал дэд цэсэнд албан хаагчдад хамаарах тогтоол шийдвэрийг тухай бүр байршуулсан бөгөөд албан хаагч, ажилтны ёс зүйг хуулийн дагуу дагаж мөрдөн ажиллаж байна. “Ил тод байдал” цэсийн “Хүний нөөцийн ил тод байдал” дэд цэсний “Ёс зүйн зөвлөл” хэсэгт https://mddc.gov.mn/mn/%d1%91%d1%81-%d0%b7%d2%af%d0%b9%d0%bd-%d0%b7%d3%a9%d0%b2%d0%bb%d3%a9%d0%bb/ дүрэм, журам байршсан. | 100% |
| 14 | 2.4. Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам; | Цахим хуудасны “Ил тод байдал” цэсний “Хүний нөөцийн удирдлага” https://mddc.gov.mn/mn/%d1%85%d2%af%d0%bd%d0%b8%d0%b9-%d0%bd%d3%a9%d3%a9%d1%86%d0%b8%d0%b9%d0%bd-%d1%83%d0%b4%d0%b8%d1%80%d0%b4%d0%bb%d0%b0%d0%b3%d0%b0/ дэд цэсэд Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журмыг байршуулсан. | 30% |
| 15 | 2.5. Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ; | Цахим хуудаст “Ил тод байдал” цэсийн “Хүний нөөцийн ил тод байдал” дэд цэсэд “Хүний нөөцийн удирдлага” https://mddc.gov.mn/mn/%d1%85%d2%af%d0%bd%d0%b8%d0%b9-%d0%bd%d3%a9%d3%a9%d1%86%d0%b8%d0%b9%d0%bd-%d1%83%d0%b4%d0%b8%d1%80%d0%b4%d0%bb%d0%b0%d0%b3%d0%b0/ | 100% |
| 16 | 2.6. Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам. | Цахим хуудаст “Ил тод байдал” цэсийн “Хүний нөөцийн ил тод байдал” дэд цэсэд “Хүний нөөцийн удирдлага” хэсэгт https://mddc.gov.mn/mn/%d1%85%d2%af%d0%bd%d0%b8%d0%b9-%d0%bd%d3%a9%d3%a9%d1%86%d0%b8%d0%b9%d0%bd-%d1%83%d0%b4%d0%b8%d1%80%d0%b4%d0%bb%d0%b0%d0%b3%d0%b0/ байршсан. | 100% |
| Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал | | | |
| 17 | 3.1. Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл; | Цахим хуудасны “Шилэн данс” цэсэд https://shilendans.gov.mn/organization/4097?ry=2023 “Шилэн дансны цахим систем”-ийг холбож тухай бүр мэдээллийг тайлагнан ажиллаж байна. Шилэн дансанд байршуулсан мэдээллээс 1 мэдээ хугацаа хоцорч мэдээлсэн байна. | 100% |
| 18 | 3.2. Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан; | Цахим хуудасны “Шилэн данс” цэсэд https://shilendans.gov.mn/organization/4097?ry=2023 “Шилэн дансны цахим систем”-ийг холбож тухай бүр мэдээллийг тайлагнан ажиллаж байна. Шилэн дансанд нийт 14 мэдээлэл байршуулахаас 13 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг мэдээлэх хуулийн хугацаа болоогүй байна. /дараа оны 04 дүгээр сарын 25-ны дотор/ | 100% |
| 19 | 3.3. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт; | Цахим хуудасны “Шилэн данс” цэсэд https://shilendans.gov.mn/organization/4097?ry=2023 “Шилэн дансны цахим систем”-ийг холбосон. | 30% |
| 20 | 3.4. Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ; | Цахим хуудасны “Шилэн данс” цэсэд https://shilendans.gov.mn/organization/4097?ry=2023 “Шилэн дансны цахим систем”-ийг холбож тухай бүр мэдээллийг тайлагнан ажиллаж байна. Шилэн дансанд нийт 12 мэдээлэл байршуулахаас 12 мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлсэн. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| 21 | 3.5. Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар; | Цахим хуудасны “Шилэн данс” цэсэд https://shilendans.gov.mn/organization/4097?ry=2024 “Шилэн дансны цахим систем”-ийг холбож тухай бүр мэдээллийг тайлагнан ажиллаж байна. Шилэн дансанд нийт 12 мэдээлэл байршуулахаас 12 мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлсэн. | 100% |
| 22 | 3.6. Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг; | Цахим хуудасны “Шилэн данс” цэсэд https://shilendans.gov.mn/organization/4097?ry=2023 “Шилэн дансны цахим систем”-ийг холбож тухай бүр мэдээллийг тайлагнан ажиллаж байна. Шилэн дансанд нийт 12 мэдээлэл байршуулахаас 12 мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлсэн. | 100% |
| 23 | 3.7. Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт; | Цахим хуудасны “Шилэн данс” цэсэд https://shilendans.gov.mn/organization/4097?ry=2023 “Шилэн дансны цахим систем”-ийг холбож тухай бүр мэдээллийг тайлагнан ажиллаж байна. Шилэн дансанд нийт 12 мэдээлэл байршуулахаас 12 мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлсэн. | 100% |
| 24 | 3.8. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр; | Цахим хуудасны “Шилэн данс” цэсэд https://shilendans.gov.mn/organization/4097?ry=2023 “Шилэн дансны цахим систем”-ийг холбож тухай бүр мэдээллийг тайлагнан ажиллаж байна. Шилэн дансанд нийт 12 мэдээлэл байршуулахаас 12 мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлсэн. | 100% |
| 25 | 3.9. Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл; | Цахим хуудасны “Шилэн данс” цэсэд https://shilendans.gov.mn/organization/4097?ry=2023 “Шилэн дансны цахим систем”-ийг холбож тухай бүр мэдээллийг тайлагнан ажиллаж байна. Шилэн дансанд нийт 1 мэдээлэл байршуулахаас 1 мэдээллийг хугацаанд нь байршуулсан. | 100% |
| 26 | 3.10. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан; | Цахим хуудасны “Шилэн данс” цэсэд https://shilendans.gov.mn/organization/4097?ry=2024 “Шилэн дансны цахим систем”-ийг холбож тухай бүр мэдээллийг тайлагнан ажиллаж байна. Шилэн дансанд нийт 12 мэдээлэл байршуулахаас 11 мэдээллийг хуулийн хугацаанд, 1 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн. | 100% |
| 27 | 3.11. Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт; | Цахим хуудасны “Шилэн данс” цэсэд https://shilendans.gov.mn/organization/4097?ry=2023 “Шилэн дансны цахим систем”-ийг холбож тухай бүр мэдээллийг тайлагнан ажиллаж байна. Шилэн дансанд нийт 12 мэдээлэл байршуулахаас 12 мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлсэн. | 100% |
| 28 | 3.12. Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн | Цахим хөгжил, харилцаа холбооны яамны цахим хуудасны шилэн данс цэсэнд ил тод байршуулан ажиллаж байна. Шилэн данс цэс нь https://shilendans.gov.mn/ хаягт шууд холбогдох ба ил тод байршуулахаар заасан бүхий л мэдээллийг тус сайтаас үзэх боломжтой байна. Одоогоор мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл; | этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан мэдээлэл байхгүй байна. | |
| 29 | 3.13. Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн; | Тус яаманд хамаарах төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр байхгүй тул холбогдох мэдээлэл одоогоор байхгүй ба Шилэн дансанд нийт 13 мэдээлэл байршуулахаас 10 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн. | 100% |
| 30 | 3.14. Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан; | Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажлыг яамны цахим хуудасны "Ил тод байдал" цэсэд "Судалгаа" дэд цэсэд https://mddc.gov.mn/mn/%d1%81%d1%83%d0%b4%d0%b0%d0%bb%d0%b3%d0%b0%d0%b0/ байршуулсан. | 100% |
| 31 | 3.15. Хууль тогтоомжид заасан бусад. | Яамны цахим хуудаст "11-11 төв" https://www.11-11.mn/ цэс болон "e-mongolia" https://e-mongolia.mn/start цэсийг тус тус байршуулсан болно. | 100% |
| | Дөрөв. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал | | |
| 32 | 4.1. Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл; | Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас 2 төрлийн үйлчилгээ буюу тоон гарын үсгийн тусгай зөвшөөрөл олгох, мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх эрхийг олгодог бөгөөд яамны цахим хуудасны ил тод цэсний үйл ажиллагааны ил тод байдал дэд цэсэнд тоон гарын үсгийн "тусгай зөвшөөрөл" дэд цэсэд бүрдүүлэх баримт бичгийн мэдээллийг байршуулсан болно. Цахим хөгжил, харилцаа холбооны яам нь төрийн захиргааны төв байгууллага бөгөөд гадагш чиглэсэн үйлчилгээ үзүүлдэггүй. Иймд аливаа бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл байхгүй. https://mddc.gov.mn/mn/%d1%82%d1%83%d1%81%d0%b3%d0%b0%d0%b9-%d0%b7%d3%a9%d0%b2%d1%88%d3%a9%d3%a9%d1%80%d3%a9%d0%bb/ тусгай зөвшөөрөл хүсэгчийн бүрдүүлэх баримт бичгийн мэдээллийг байршуулсан. | 100% |
| 33 | 4.2. Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа. | Цахим хөгжил харилцаа холбооны яамнаас тоон гарын үсгийн тусгай зөвшөөрөл олгогддог бөгөөд яамны цахим хуудасны ил тод байдал цэсний үйл ажиллагааны ил тод дэд цэсэнд тоон гарын үсэг олгож буй байгууллагуудын мэдээллийг ил тод байршуулсан. Яамны цахим хуудасны "Ил тод байдал" цэсийн "үйл ажиллагааны ил тод байдал" дэд цэсэд https://mddc.gov.mn/mn/ тусгай зөвшөөрөл олгоход шаардагдах баримт бичгийн мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаягийг байршсан. Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журмыг яамны цахим хуудасны хууль, эрх зүй цэсийн "Бодлогын баримт бичиг" дэд цэсэд https://mddc.gov.mn/mn/%d1%85%d1%83%d1%83%d0%bb%d1%8c-%d1%8d%d1%80%d1%85-%d0%b7%d2%af%d0%b9/ байршуулсан. | 100% |
| | Тав. Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал | | |
| 34 | 5.1. Олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал; | Цахим хөгжил, харилцаа холбооны яамны цахим хуудасны хууль эрх зүй цэсэнд ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧИГТ САНАЛ АВАХ хэсэгт нээлттэй байршуулсан байна. линк: https://mddc.gov.mn/mn/%d1%85%d1%83%d1%83%d0%bb%d1%8c-%d1%8d%d1%80%d1%85-%d0%b7%d2%af%d0%b9/ | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| 35 | 5.2. Эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт; | Одоогоор Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хамаарах оюуны өмчийн эрх байхгүй болно. | Х.Б |
| 36 | 5.3. Хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл; | Тус яаманд хамаарах "хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл" байхгүй тул цахим хуудаст оруулах мэдээлэл байхгүй. | Х.Б |
| 37 | 5.4. Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл; | Цахим хөгжил, харилцаа холбооны яамны эзэмшилд газар байхгүй тул мэдээлэл оруулах боломжгүй байна. | Х.Б |
| 38 | 5.5. Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг; | Цахим хөгжил, харилцаа холбооны яам нь төсвийн байгууллага учраас оруулах мэдээлэл байхгүй. | Х.Б |
| 39 | 5.6. Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл; | Цахим хөгжил, харилцаа холбооны яам нь төсвийн байгууллага учраас оруулах мэдээлэл байхгүй. | Х.Б |
| 40 | 5.7. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл; | Цахим хөгжил, харилцаа холбооны яам нь төсвийн байгууллага учраас оруулах мэдээлэл байхгүй. | Х.Б |
| 41 | 5.8. Мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, | Цахим хөгжил, харилцаа холбооны яам нь төрийн захиргааны төв байгууллага тул үйлдвэрлэл үйлчилгээ явуулдаггүй болно. | Х.Б |

| | | | |
|---|---|---|---|
| | байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл; | | |
| 42 | 5.9. Барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт; | Тус яаманд хамаарах барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт зэрэг мэдээлэл байхгүй. | Х.Б |
| 43 | 5.10. Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ; | Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хамааралгүй байна. | Х.Б |
| 44 | 5.11. Нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл; | Цахим хөгжил, харилцаа холбооны яамны цахим хуудасны “Ил тод байдал” цэсийн “Нээлттэй өгөгдөл” https://mddc.gov.mn/mn/%d0%bd%d1%8d%d1%8d%d0%bb%d1%82%d1%82%d1%8d%d0%b9-%d3%a9%d0%b3%d3%a9%d0%b3%d0%b4%d3%a9%d0%bb/ дэд цэсэд байршсан. | 100% |
| 45 | 5.12. Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт; | Одоогоор Цахим хөгжил, харилцаа холбооны яамны зардлаар суралцаж байгаа албан хаагч байхгүй байна. | Х.Б |
| 46 | 5.13. Хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл. | Цахим хөгжил, харилцаа холбооны яам нь Хууль зүйн яамтай хамтран Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон түүнийг даган гарсан журмыг боловсруулж батлуулах арга хэмжээг авч ажилласан бөгөөд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу яамны цахим хуудаст нээлттэй байхаар заасан бүхий л мэдээллийг ил тодоор байршуулан ажиллаж байна. Линк: https://mddc.gov.mn/mn/ | 100% |

-оОо-

# ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ УДИРДЛАГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 02 сарын 06 өдөр Дугаар 02 Улаанбаатар хот

Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн 2023 оны жилийн эцсийн биелэлтийн тухай

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны “Ил тод байдлын шалгуур үзүүлэлт”-ийн 2023 оны жилийн эцсийн биелэлтийн талаар:

Хурлыг 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 10 цагаас тус яамны “Хурлын танхим”-д эхлүүлж, Төрийн нарийн бичгийн дарга Б.Батцэцэг удирдан явуулав. Хуралд:

1.Б.Билэгдэмбэрэл /Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга/

2.Ц.Борхүү /Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга/

3.Ц.Эрдэнэбаяр /Төрийн захиргааны удирдлагын газрын дарга/

4.Л.Нямдорж /Хуулийн хэлтсийн дарга/

5.Б.Золбоо /Цахим засаглалын хэлтэс/

6.Д.Батбаяр /Нийтийн мэдээллийн дэд бүтцийн хэлтсийн дарга/

7.П.Дэлгэрмаа /Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга/

Хэлэлцэж байгаа асуудлуудтай холбогдуулан Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын шинжээч А.Түвшинзаяа оролцов.

Хэлэлцсэн асуудал:

Тус яаманд хамаарах ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн 46 заалтын хэрэгжилтэд 2023 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг танилцуулах тухай;

СОНССОН нь:

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны чиг үүрэгт хамаарах ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтэд 2023 оны жилийн эцсийн байдлаар байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийснийг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн шинжээч А.Түвшинзаяа танилцуулав. /Биелэлт, биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тэмдэглэлийг хавсаргав/

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь 2023 оны жилийн эцсийн байдлаар байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хуулийн хугацаанд хүргүүлэхийг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ц.Борхүү/-т даалгаж шийдвэрлэв.

Хоёр. Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн тайланг тогтоосон хугацаанд тухай бүр тайлагнаж хэвшихийг Төрийн захиргааны удирдлагын газар /Ц.Эрдэнэбаяр/-т үүрэг болгов.

Хурал 10 цаг 30 минутад дуусав.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Б.БАТЦЭЦЭГ